



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/54

Сүхбаатар сум

### Журам боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр 29.1.3. "н", 29.1.6. "а", "в", 30 дугаар зүйлийн 30.1.6, 39 дүгээр зүйлийн 39.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5<sup>2</sup>.1, 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.2, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.4, 16.2.10, 22 дугаар зүйлийн 22.3, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1, 56 дугаар зүйлийн 56.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмал хайх, ашиглах, бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг таслан зогсоож, цаашид гаргуулахгүй байх зорилгоор аймгийн нутаг дэвсгэр дэх авто замын постуудаар нэвтэрч буй уул уурхайн техник хэрэгслүүдийг шалгаж нэвтрүүлэх журам боловсруулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч

Д.Ёндонжамц

-Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга

М.Эрдэнэбилэг

-Аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч

Гишүүд

З.Түвшинтөгс

-Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Ж.Отгонхүү

-Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга


Ж.Батцогт

-Авто тээврийн төвийн дарга

2. Журмын төслийг боловсруулж, 2020 оны 3 сарын 9-ний дотор танилцуулан ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ОРГИЛ



C:\users\albanbichig2020\zahiramjA4.docx

430801147